

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2017.07.24-2017.08.25/

НЭГ: УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус 8, 9-р хуралдаан 2017 оны 08 сарын 02, 17-ны өдрүүдэд хуралдаж сумын эрүүл мэндийн төвийн хуучин барилгыг 3-р цэцэрлэгт цэцэрлэгийн зориулалтаар ашиглуулах шийдвэр гаргасан байна.

Засаг даргын 2017 оны А/72 тоот захирамжаар “Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах” ажлын хэсэг томилогдон өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах ажлын төлөвлөгөөний дагуу байгууллагуудаар шалгалт хийж, малчин, мал бүхий иргэдэд өвөлжилтийн бэлтгэл хангах албан даалгаврыг хүргүүлэн ажиллаж байна. 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилт 69,4%-ийн гүйцэтгэлтэй байна.

Сумын баяр наадмыг 2017 оны 07-р сарын 30-ны өдөр зохион байгуулж 3-н насны морь уралдаж сур, шагайн харваачид онч мэргэнээ сорилоо.

Хүчит бөхийн барилдаанд 64 бөх барилдсанаас Говьсүмбэр аймгийн залуу бөх С.Мөнх-Эрдэнэ түрүүлж сумын “Заан” цолны болзол, Говьсүмбэр аймгийн залуу бөх Б.Мягмаржав үзүүрлэж сумын “Начин” цолны болзолыг тус тус хангалаа. Мөн хүүхдийн бөхийн барилдааныг 10-13, 14-16 насны ангиллаар зохион байгуулж үзүүр, түрүүг шалгарууллаа.



Сумын Засаг даргын 2017 оны А/84 тоот захирамжаар газар эзэмших төсөл сонгон шалгаруулалтын ажлын хэсэг томилогдож 2017 оны 08-р сарын 12-ны өдөр сумын 1 дүгээр багийн нутаг давсгэр 14 дүгээр байрны хойд талд “Эмийн сан”-гийн зориулалтаар төсөл сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулж “Оргил дэнж” ХХК шалгарлаа.

ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

2017 оны 8-р сарын 25-ны байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	ИТХ	28504,1	27083,3
2.	ЗДТГ	179468,1	173806,1

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	Эрүүл мэндийн төв	196989,5	186325,9
2.	Соёлын төв	35250,5	31050,5
3.	3-р сургууль	539305,3	518675,9
4.	3-р цэцэрлэг	247534,1	227516,1

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Сумын Засаг Даргын 2017 оны А/82 тоот Захирамжаар Монгол Улсын үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хэсгийг 17 хүний бүрэлдэхүүнтэй томилон сургалт, хэлэлцүүлгийг 3 үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

1, 2 дугаар үе шатны сургалт, хэлэлцүүлгийг 2017 оны 08 дугаар сарын 22, 24-ний өдрүүдэд зохион байгуулж төслийн талаар 50 иргэдийн саналыг авч ажиллаа.

Аймгийн ГХУСЗАЗЗөвлөлийн 500000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын ГХУСЗАЗЗөвлөл сумын төв зам дагуу 10 ширхэг замын тэмдэг, тэмдэглэгээнүүдийг хийж байршуулсан.



3-р Сургууль

3-р сургуулийн сантехникийн засварын ажлыг 1-р багийн иргэнтэй гэрээ байгуулан 70%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.



Сургуулийн гадаах тохижилт, ногоон байгууламжийн ажил 80%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж, ургац хураан авалт 25-30%-тай явагдаж байна.

3-Р ЦЭЦЭРЛЭГ



Хичээлийн шинэ жилийн бэлтгэлийг хангаж, анги бүлэг, коридорын цэвэрлэгээ үйлчилгээ, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

2017 оны 08 сарын 21-нд хичээлийн жилийн хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж, багш нарын дунд хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Цэцэрлэгийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахаар 11 ажил төлөвлөснөөс 9,5 ажил хийгдэж төлөвлөгөөний биелэлт 86,4%-тай байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Эрүүл мэндийн төвд 44 өвчтөн хэвтэж үүнээс хүүхэд-14, дотор- 30 хэвтэн эмчлүүлж байна.

Эмнэлгийн үйлчилгээ нь:

1. Урьдчилан сэргийлэх үзлэг – 18
2. Дуудлага-148
3. Амбулаторийн үзлэгт-185 иргэн хамрагдсан áàéí à.

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2017 оны 08 сарын 14-ний өдрийн байдлаар суманд 83%-тай явагдаж байна. Нийт 612 иргэн шинжилгээнд

хамрагдаж, 82 иргэнээс элэгний В, С вирус илэрч 15 иргэн нь эмчилгээнд хамрагдаад байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахаар 4 ажил төлөвлөснөөс 3 ажил хийгдэж төлөвлөгөөний биелэлт 75%-тай байна.



Говьсүмбэр аймагт Эрүүл мэндийн салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн баярын хүрээнд 2017 оны 08 сарын 01-нд зохион байгуулагдсан “Миний мэргэжил- Бидний бахархал” ажил мэргэжлийн уралдаанд Г. Даваажав ахлагчтай НАРРУ баг 3-р байр эзэлсэн.

Говьсүмбэр аймагт Эрүүл мэндийн салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн баярын арга хэмжээ 2017 оны 07 сарын 28-ны өдөр зохион байгуулагдаж “Онол судалгаа дэвшил” Онол практикийн хуралд ЭМТ-ийн дарга П.Ганчимэг, 1-р багийн эмч Г.Даваажав нарын илтгэл 1-р байранд шалгарсан. Мөн энэ үеэр ЭМЯ-ны ЭМХ-ийн тэргүүний ажилтанаар 4, 90 жилийн ойн медаль, Залуучуудын холбооны медалиар 4 ажилтан тус тус шагнагдлаа.



Хөдөөгийн малчин өрхөд урьдчилан сэргийлэх үзлэг, гэрийн эргэлтийг 08 сарын 07-ны өдөр хийж “Хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллолтыг дэмжих” сургалт сурталчилгааг зохион байгуулж ажиллаа.



МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСАГ

Сумын худаг, уст цэгийн тооллогийн ажлыг зохион байгуулж бэлчээрийн 56 худаг, төв суурингийн 4 худаг, 3 булаг, 1 нуурыг тооллогод хамруулан ажиллаа.



Хэнтий аймагт зохион байгуулагдсан “Зүүн бүсийн хөдөө аж ахуйн ажилчдын уулалт, семинарт МЭҮТ-ын дарга, мэргэжилтэн нар хамрагдлаа.



Сумын Засаг даргын 2017 оны 8 сарын А/83 дугаар захирамжийн дагуу 5 өрхийн 5436 толгой мал угаалгад хамрагдаад байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 122-р тогтоолын дагуу 2017 онд хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан Шивээговь сумын малчин, мал бүхий иргэдийн жагсаалтыг гарган аймгийн ХХААГ-т хүргүүлсэн.

Сумын малчин, мал бүхий иргэдэд “Малын индексжүүлсэн даатгал”-ын тухай гарын авлага тарааж, ач холбогдлын тухай сурталчилгаа хийх ажлыг зохион байгууллаа.

НИЙГМИЙН БОДЛОГО

Сумын СӨБ-д хамрагдах 2-5 насны хүүхдийн судалгааг гаргаж 3-р цэцэрлэгт хүргүүлсэнээр 2017 оны 08 дугаар сарын 23-25 хооронд бүртгэл явагдаж байна. Үүнд: 2 настай - 81, 3 настай – 113, 4 настай – 113, 5 настай – 82 хүүхэд байна.

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас ирсэн албан бичгийн дагуу Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт харъяалагдаж байсан 54 ахмад настанаас 12

ахмад настанг суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, хувиараа бизнес эрхлэгч иргэдэд харъяалууллаа.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Сумын төвийг камержуулах ажлын гүйцэтгэгчээр Говьсүмбэр аймгийн “Чойрын долгио” ХХК шалгарч сумын төвийн 6 цэгт 2 эргэдэг, 4 чиглэлийн камер суурилуулж комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болсон байна.



Илчлэг шивээ ОНӨҮГазарт бага оврын зуух авах, угсарч суурилуулах ажлыг “Илчит сансар” ХХК гүйцэтгэж 70%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.

3, 8-р байранд хэрэглээний халуун усны шугам тавих ажлыг сумын иргэдийн “Илч” бүлэг хийж гүйцэтгэн комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болоод байна.



